



САЙНЦАГААН СУМЫН
МАНДАЛ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ М.ЭНХБАЯР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgov@audit.gov.mn

2017.02.28 № 01/35 ДУА-2017/136/СТА-ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Сайнцагаан сумын Мандал сургуулийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас нийлүүлэгдсэн 7,794,000.00 /Долоон сая долоон зуун ерэн дөрвөн мянга/ төгрөгийн ухаалаг самбар, проектор зэрэг үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д /Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө:/, 4.1.1 /Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт/, Сангийн сайдын “Эдийн засгийн ангилал батлах тухай” 2014 оны 05 дугаар тушаалын 6-р хавсралт, УСНББОУС-17-ын 13 дугаар зүйлийг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад шлэрсэн толбор, зорчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага огх, хууль тогтоомж, эрх зүйн хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронд болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад шлэрсэн толборийг барагдуулах, зорчлийг арилгуулах зорилгоор толборийн акт, албан шаардлага огх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хотлоогүй/ гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:


1. Бараа материалын дансанд бүртгэсэн үндсэн хөрөнгийг холбогдох байгууллагын шийдвэрийг үндэслэн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, 2017 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайланд залруулах.

1001000712

2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2017 оны 04 дүгээр сарын 25-ны дотор ирүүлэхийг Сайнцагаан сумын Мандал сургуулийн захирал /М.Энхбаяр/, нягтлан бодогч /Т.Эрдэнэтуюя/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:



Ахлах шинжээч

Ч.Бэрхсайхан

Захирал

Нягтлан бодогч



М.Энхбаяр

Т.Эрдэнэтуюя

ТТБ9067 № 3432882

ЗӨВШӨӨРСӨН:

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангаждваагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил зараасан албан тушаалтныг үүрзэт эжлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүнэ" гэж засны дэгүү хариуцаач албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлна.